



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 – 2024

**ХОТЫН СТАНДАРТ,
ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

ГАРЧИГ

ОРШИЛ	2
АЛСЫН ХАРАА	3
ЭРХЭМ ЗОРИЛГО	3
ҮНЭТ ЗҮЙЛС	3
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	4
ГАЗРЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГ	4
ГАЗРЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	4
ХЭЛТСҮҮДИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	5
ХҮНИЙ НӨӨЦ	11
ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	12
СТАНДАРТ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО	13
СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ	14
ЧАНАРЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО /ISO9001:2015/	15
ЧАНАРЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЭЛТ	16
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	18
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ	18
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ХОЁР. ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ	20
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ГУРАВ. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР	22
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ДӨРӨВ. ЧАНАРЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ	26
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ТАВ. ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ	26
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ЗУРГАА. ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА	29
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ	31
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	32
ЕРӨНХИЙ ЭРСДЭЛ	32
ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТНЫ ЭРСДЭЛ	33
СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ	33
ХОТЫН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭХ, МӨРДҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ	34
ЧАНАРЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЭЛТИЙН ЭРСДЭЛ	35

ОРШИЛ

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар байгуулагдсанаар Нийслэл Улаанбаатар хотын Нутгийн захиргааны байгууллагууд хөгжлийнхөө нэгэн шинэ шатанд дэвшин орж байна. Монгол улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэсэн байдаг. Энэ чиг үүрэг нэн түрүүнд манай байгууллагад хамаарах бөгөөд бидний үндсэн зорилго бол Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих, Нийслэлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах явдал юм.

Бид угтан ирж буй он жилүүдэд байгууллагын үйл ажиллагааны үр шимийг хүртэгч бүх талуудад хүргэх үйлчилгээнийхээ чанар хүртээмжийг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлсэн шинэ жишиг тогтоон ажиллах нөөц, чадамжийг бүрдүүлэх нь хөгжлийн зорилтыг тодорхойлох гол чиглэл болно. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд бид Нийслэл хотын өнөөгийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, эрх зүйн орчинд шинэчлэлт хийн, тасралтгүй сайжрах тогтолцоог бий болгоод зогсохгүй, иргэд, олон нийт, бизнесийн байгууллагуудад нөлөөлөх өргөн боломж байгааг бүрэн дүүрэн ашиглах ёстой. Байгууллагын хөгжлийг төлөвлөхдөө бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох талуудтай хэлэлцэн зөвшилцөж, зорилгодоо хүрэх шийдлийг оновчтойгоор тодорхойлох нь нэн чухал юм.

Бидний танилцуулж буй энэхүү стратеги төлөвлөгөө нь манай байгууллагын хамт олны оролцоонд түшиглэж, тэдний хүсэл зоригийг илэрхийлэх эрмэлзлээр боловсруулсан хүчин чармайлтын үр дүн болно. Тусгайлан боловсруулсан судалгааны асуулга, холбогдох мэдээлэл баримтын шинжилгээ, төрөлжсөн баг хамтлагаар зохион байгуулсан хэлэлцүүлэг, эксперт зөвлөхүүдтэй хийсэн уулзалт зөвлөгөөн, мэдээллийн сувгуудаар дамжуулан цуглуулсан санаа оноо нь ийнхүү дүгнэхийн бодит үндэс болж байна. Иймд энэ төлөвлөгөөг Хотын стандарт, орчны аюулгүй байдал хяналт зохицуулалтын газрын хамт олон өөрсдийнхөө ирээдүйн төлөө гар нийлэн боловсруулсан бодлогын баримт бичиг гэж нэрлэж болно.

Стратегийн энэхүү төлөвлөгөө нь даян дэлхийн хүн төрөлхтний мэдлэг туршлагад түшиглэн шинэ оргилд хүрэх үндсэн алхмуудыг тусгаж чадсан хэмээн үзэж байна. Үүгээрээ энэ баримт бичиг, Та, Бид хамтдаа Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, Хотын стандарт, норм, дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих, Мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах, бүтээлч зорилгодоо хүрэх үндсэн удирдамж, гол хөтөч байх болно.

Бид байгууллагынхаа алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, тэргүүлэх чиглэлүүдийг удирдамж болгон ажилладаг.

АЛСЫН ХАРАА

“Бид шинэ бүхний эхлэл, даацтай хөгжлийн тулгуур, байж байгууллагын чадавхад тулгуурлан чанарыг түгээж, хотын стандарт хэрэглэгчдийн зорилгыг биелүүлнэ”

ЭРХЭМ ЗОРИЛГО

“Хотын стандартыг боловсруулан нэвтрүүлж хэрэгжилтийг хангуулах замаар байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангана”.

ҮНЭТ ЗҮЙЛС

Эдгээр үнэт зүйлс нь алсын хараандаа хүрэхэд бидний үйл ажиллагааг цаг ямагт чиглүүлж байх зүг заагчийн үүрэг гүйцэтгэнэ.

ЁС ЗҮЙ БИД төрийн алба, хувь хүний ёс зүйг дээдлэн сахиж, үнэнч шударга, ил тод байдлыг эрхэмлэн, бие биедээ болон хамтран ажилладаг бүх хүнтэй харилцан итгэлцлийг бэхжүүлж ажиллана.

МАНЛАЙЛАЛ БИД үндэсний эрх ашгийг дээдлэн хүндэтгэж, нийтийн сайн сайхны төлөө зүтгэх, нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах итгэл үнэмшлийн төв манлайлагч байна.

ХАРИУЦЛАГА БИД ажил, үүрэг, хийхээр биедээ хүлээсэн амлалт бүрээ чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх ухамсартай байж, гарах үр дагаврыг хүлээж ажиллана.

УР ЧАДВАР БИД хувийн үнэ цэнийг бүтээн, шинжлэх ухаанч хандлага, эмх цэгц, үр дүнтэй зохион байгуулалт бүхий мэргэжлийн ур чадвартай мэргэжилтэн орлуулшгүй баялаг байна.

ХАМТ ОЛОН БИД амжилтад хүрэхийн тулд мэргэжлийн урам зоригоор дүүрэн ажлын орчинг бий болгож, үр дүнг бүтээлцэхийг зорьсон чадварлаг хамт олон байна.

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 -оос 2024 онд гүйцэтгэх үйл ажиллагааны Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд орчны шинжилгээг гүйцэтгэхдээ газар байгуулагдсанаас хойш 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/556 дугаар захирамжийн хүрээнд хийгдсэн орчны судалгаа, Нийслэлийн нутгийн Захиргааны байгууллагуудын хэрэгжүүлэн ажиллаж байгаа стандарт баримт бичгийн судалгаа, дотоод эрх зүйн орчны шинжилгээ, болон гадаадын улс орнуудын туршлагатай харьцуулсны үндсэн дээр боловсруулав.

ГАЗРЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол улсын засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн №100 дугаар тогтоолоор байгуулагдаж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 15 -ны өдрийн №А/305 дугаар тоот захирамжаар батлагдсан дүрмийн дагуу 32 хүний бүрэлдэхүүнтэй 4 хэлтэстэй үйл ажиллагаагаа явуулж байгаад 2019 оны 12 сарын 2 -ны өдрийн А/1273 дугаар тоот захирамжаар ба бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж 60 хүний бүрэлдэхүүнтэй 5 хэлтэстэй болсон байна.



ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГ

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар нь Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах чиг үүрэгтэй.

ГАЗРЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Үндэсний хөгжлийн хөтөлбөрүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, болон Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн үзэл баримтлал, хот байгуулалт төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийслэлийн иргэдийн аюулгүй, тохилог орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн ажлуудыг хууль, эрх зүйн хүрээнд гүйцэтгэж байна. Газрын бүтээгдэхүүн үйлчилгээ.

1. ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭ
2. ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ
3. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ
4. ХОТЫН СТАНДАРТ
5. СУРГАЛТ
6. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

ХЭЛТСҮҮДИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар нь Захиргааны хэлтэс, Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс гэсэн 5 хэлтэстэй бөгөөд хэлтсүүдийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг Газрын дарга дараах байдалтайгаар зохион байгуулсан байна. Үүнд:

ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС

Зорилго

Газрын дүрэм, дотоод журмын хэрэгжилтийг зохион байгуулах, албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангах, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах, хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангах, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмын дагуу явуулах, мэргэшсэн тогтвортой, чадварлаг баг бүрдүүлж газрын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангахад чиглэнэ.

Үйл ажиллагааны чиглэл

- Газрын үйл ажиллагаатай холбогдоотой хууль, дүрэм, журам, дээд газрын тогтоол шийдвэрийг мөрдүүлж, биелэлтэд хяналт тавьж, холбогдох тайлан, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх;
- Газрын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм болон бусад холбогдох дүрэм журмыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, батлах эрх бүхий байгууллагад хүргүүлэх.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчдын ХАСХОМ-ийг хүлээн авах, бүртгэх, хянах, баталгаажуулах, мэдэгдэл, тайлбарыг заасан хугацаанд гаргуулан авч бүртгэх, холбогдох тайлан мэдээг заасан хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх;
- Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайланг боловсруулах, нэгтгэх;
- Газраас гарч буй захиргааны шийдвэр хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд эрх зүйн талаас хяналт тавих, туслалцаа үзүүлэх;

- Хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог хангаж, хүний нөөц, хууль эрх зүй, архив бичиг хэрэг, дотоод ажил үүргийн чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;
- Газрын даргын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах;
- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- Газрын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэн авч, шийдвэрлэлтэд, хяналт тавих;
- Ажилтан албан хаагчийг урамшуулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэг дэв, шатлал ахиулах, ажиллах нөхцөл, баталгаагаар хангуулах, хариуцлага тооцох;
- Төрийн албан хаагчийг мэргэшил, ур чадвар олгох сургалтад үе шаттай хамруулах;
- Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх, хуульд заасан бусад тусламж, дэмжлэг үзүүлэх;
- Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих;
- Удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийн мэдээ, тайланг хугацаанд гаргаж, холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэх;

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

Зорилго

Хотын стандарт боловсруулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, урт дунд хугацааны хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах, техникийн туслалцаа үзүүлэх замаар иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах.

Үйл ажиллагааны чиглэл

- Байгууллагын зорилго, үндсэн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хөгжлийн урт болон дунд хугацааны стратеги боловсруулах, бодлого тодорхойлох;
- Хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх, дүгнэлт өгөх;
- Байгууллагын үйл ажиллагааг удирдамж, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;
- Стандарт, Техникийн зохицуулалтын баримт бичгийн сан бүрдүүлэх, хөтлөх, түгээх;

- Хотын стандартын баримт бичигт судалгаа шинжилгээ хийх, хэрэгжилт болон орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох, санал дүгнэлт боловсруулах;
- Хотын стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулах, холбогдох байгууллагаар батлуулах ажлыг зохион байгуулах;
- Төрийн албан хаагч, иргэн, аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх;
- Олон улсын стандартын байгууллага /ISO/ болон Европын холбооны тогтолцоог нэвтрүүлж, хотын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах талаар мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох талаар хамтран ажиллах;
- Өндөр хөгжилтэй орны хөгжлийн туршлага, шинэлэг арга зүй, дэвшилтэт технологийг судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Иргэдийн хотын амьдралд оролцох мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулах ажлыг зохион байгуулах;
- Хотын стандартын “Мэргэжлийн зөвлөл” –ийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Гадаад дотоодын ижил төстэй байгууллагуудтай олон улсын стандартыг нэвтрүүлэх, туршлага солилцох, зөвлөгөө авах талаар хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;
- Чиг үүргийн хүрээнд гарсан маргаантай асуудлаар хуулийн байгууллагад нотлох баримт гаргах, тайлбар өгөх, шаардлагатай тохиолдолд хариуцагч, нэхэмжлэгчээр оролцох;
- Удирдлагын баримт бичгийн шийдвэрийн төслийг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн хэлэлцүүлэг хийх, сонсох ажиллагаа явуулах, эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдэд шийдвэрийг танилцуулах арга хэмжээг авч ажиллах;

СТАНДАРТ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТЭС

Зорилго

Хотын стандартын хэрэгжилтийг хот төлөвлөлт, хот байгуулалт, хотын бүтээгдэхүүн, үйлчилгээний үе шат бүрд хангуулж төрийн байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх замаар иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл

- Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд холбогдох стандартыг мөрдүүлэх;
- Хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд хот байгуулалтын төсөл, арга хэмжээг холбогдох стандарт, норм, дүрэм, техникийн шаардлагад нийцүүлэх, холбогдох байгууллагаас эрх олгох баримт бичигт нарийвчлан тусгуулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах;
- Зураг төсөл боловсруулах, гүйцэтгэх үйл ажиллагаанд стандарт мөрдүүлэх;
- Барилга, инженерийн барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах;
- Хот, нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээнд хотын стандартыг мөрдүүлэх;
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах
- Хотын бүтээгдэхүүн үйлчилгээний тохирлын үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах;
- Хотын амьдралд оролцогч талуудын стандартын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулах;
- Стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг судлах, сайжруулах санал боловсруулах;
- Хотын стандартыг хэрэгжүүлэх талаар өндөр хөгжилтэй орны хөгжлийн туршлага, шинэлэг арга зүй, дэвшилтэт технологийг судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, шинэ санал санаачилга гаргах;
- Хотын стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн стандарт норм дүрмийн шаардлага хангасан ажлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, хөтлөх, үйл ажиллагаандаа ашиглах, нийтэд мэдээлэх;
- Газрын гадаад дотоод харилцаа, мэдээлэл солилцооны хэрэгсэл /маягт, акт, дүрэм, журам/ болон ажлын байрны эргономик стандарт шаардлагыг хангуулах;

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС

Зорилго

Газрын мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагааг хангах, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сан, мэдээллийн системийг бий болгох, хөтлөх, хэвийн үйл ажиллагааг хангах, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангуулах хүрээнд хууль, дүрэм, журам, холбогдох норм, стандартын мэдээллийн ил тод байдлыг хангаж үнэн бодит мэдээлэл түгээх технологийн шийдлийг боловсруулж хэрэгжүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл

- Газрын мэдээллийн технологийн(Программ хангамж, техник хангамж, сүлжээ, мэдээллийн сан) хэвийн үйл ажиллагааг хангах,

- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сан, мэдээллийн системийг бий болгох, хөтлөх, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, системийг сэргээх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- Байгууллагын дундын мэдээллийн санг байгуулж төрийн болон холбогдох бусад байгууллагыг нэгдсэн мэдээллээр хангах;
- Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангуулах хүрээнд хууль, дүрэм, журам, холбогдох норм, стандартын мэдээллийн ил тод байдлыг хангаж үнэн бодит мэдээлэл түгээх технологийн шийдлийг боловсруулж хэрэгжүүлэх.
- Мэдээллийн аюулгүй байдлын горимыг мөрдүүлж ажиллах, зөрчигдсөн үед зөрчлийг арилгах, цахим мэдээллийн сан, мэдээллийн сүлжээнд нэвтрэх эрхийг хязгаарлах зэрэг холбогдох бусад арга хэмжээ авах;
- Эрсдэлийн үнэлгээг жил бүр хийж мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх болон авах арга хэмжээний талаар санал боловсруулах;
- Программ хангамж, техник хангамж, мэдээллийн сүлжээ, техник хэрэгслийн элэгдэл хорогдол, гэмтэл саатал, доголдлоос сэргийлэх нөөц болон урсгал зардлын тооцоог жил бүр гаргаж, төсөвт тусгах саналыг боловсруулах;
- Техник хангамж, мэдээллийн сүлжээ, техник хэрэгслийн элэгдэл хорогдол, гэмтэл саатал, доголдлоос сэргийлэх, хэвийн ажиллагааг хангах, гэмтэл, саатлыг тухай бүр түргэн шуурхай засварлах арга хэмжээ авах;
- Техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тэдгээрийн аюулгүй байдлыг хариуцах;

ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

Зорилго

Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангуулах хүрээнд, түүнтэй уялдан гарсан хууль, дүрэм, журам, холбогдох норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, хэрэгжилтийг хангуулах.

Үйл ажиллагааны чиглэл

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд орчны аюулгүй байдлын хяналтыг сайжруулах талаар тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах, санал, дүгнэлт гаргах;

- Хот нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээтэй холбоотой стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;
- Хот байгуулалт, барилгажилт, түүний үйл ажиллагаанд стандартын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн ашиглалтын хэвийн байдал, түүний хамгаалалтын зурваст мөрдөгдөх дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;
- Хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой стандарт, норм дүрмийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэх талаар гадаад, дотоодын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, санал солилцох;
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Экологийн тэнцвэрийг хадгалах чиглэлээр хөрс, ус, агаа бохирдлыг бууруулах, тэдгээрийн мөрдөгдөж буй стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;
- Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүс, усан сан бүхий газрын онцгой, энгийн хамгаалалтын бүс, тэжээх мужид үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт, норм дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;
- Үерийн далан суваг, түүний хамгаалалтын зурваст тавигдах шаардлага, стандартын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад сөргөөр нөлөөлж буй зөрчлийг арилгуулах талаар холбогдох байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах;
- Яаралтай тусламжийн(Эмнэлэг, онцгой байдал, цагдаа) ажил үйлчилгээнд саад учруулж буй хүчин зүйлийн талаар судалж, судалгаагаар илэрсэн саадыг (хашаа, объектыг чөлөөлүүлэх) арилгах, иргэдийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангах, хот төлөвлөлтийн норм дүрмийн хэрэгжилтэд нь хяналт тавих;
- Хэлтсийн чиг үүрэг, шуурхай зохион байгуулах шаардлагатай үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр газрын удирдлага, бусад хэлтсийг ханган ажиллана;

ХҮНИЙ НӨӨЦ

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт 2019 оны 12 дугаар сарын 24 -ны өдрийн байдлаар 24 албан хаагч ажиллаж байна.

Байгууллагын хүний нөөцийн нөхцөл байдлыг авч үзвэл мэргэжлийн чиглэлийн хувьд өргөн салбар чиглэлийг хамарч байгаа ба хот байгуулалт, инженер, чанарын удирдлагын тогтолцооны аудитор мэргэжлээр мэргэжил дээшлүүлсэн байдал ажиглагдаж байна. Нийт албан хаагчдын боловсролын түвшин насны бүлгээр авч үзвэл магистр 29.1% буюу 7 албан хаагч, бакалавр 62.5% буюу 15 албан хаагч, тусгай мэргэжлийн 4.6% буюу 1 албан хаагч байна.

Байгууллагын хүний нөөцийн дийлэнх олонх буюу 75 хувь нь 25 -аас 35 насныхан байгаагаас үзэл харьцангуй залуу идэр насны хамт олон болох нь харагдаж байна. Насны бүлгээр авч үзвэл 25 -35 насны 17 албан хаагч, 36 -45 насны 4 албан хаагч, 46 -аас дээш насны 2 албан хаагч байна. Албан хаагчдын хүйсийн харьцаа адил байна. Нийт албан хаагчдын дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг байхгүй байна.

Албан хаагчдын орон сууцны хангамжийн түвшинд авч үзвэл 10 албан хаагч өөрийн нийтийн зориулалттай орон сууцанд, амьдарч байгаа ба 14 албан хаагч өөрийн орон сууц байхгүй түрээсийн болон бусдын орон сууц, амины сууцанд амьдарч байна.

Хүснэгт 1. Газрын албан хаагчдын боловсрол мэргэжлийн чиглэл

Мэргэжлийн чиглэл	Мэргэшил
<ul style="list-style-type: none"> • Хот ба бүс нутаг төлөвлөгч • Барилгын үйлдвэрлэлийн удирдлага • Архитектор • Газар зохион байгуулагч • Геодезийн инженер • Цахилгааны инженер • Гидрогеологийн инженер • Материал судлалын инженер • Эдийн засагч • Төрийн удирдлага • Бизнесийн удирдлага • Эрх зүйч • Архивч 	<ul style="list-style-type: none"> • Чанарын удирдлагын тогтолцооны тэргүүлэх аудитор • Чанарын удирдлагын тогтолцооны аудитор • Мэргэшсэн хот төлөвлөлтийн эдийн засагч • Олон улсын байгаль орчны манлайлагч • Мэргэшсэн инженер • Тэргүүлэх архивч,

Цаашид байгууллагын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж мэргэжилтэн албан хаагчдын мэдлэг чадвар мэргэшсэн байдлыг дээшлүүлэх гадаадын улс орнуудын мэдлэг мэдээлэл, тэргүүн туршлагаас суралцах чиглэлээр үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажиллах нь зүйтэй бөгөөд ажилтнуудын орон сууц нийгмийн хангамжид анхаарч ажиллах шаардлагатай байна.

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол улсын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн зургаадугаар бүлэгт стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаарх төрийн байгууллагын бүрэн эрхийг тусгаж өгсөн ба 25 дугаар зүйлд стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Стандарт, хэмжил зүйн газрын бүрэн эрхийг зааж өгсөн байна. Стандарт хэмжил зүйн газар нь үндэсний стандартыг боловсруулах батлах эрх бүхий байгууллага бөгөөд Олон улсын стандартын байгууллагын /ISO/ гишүүн болсон байна.

Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа норм стандартын баримт бичгийн тогтолцооны эрх зүйн орчны өнөөгийн байдлаас үзэхэд дараах асуултууд зүй ёсоор урган гарч байна. Үүнд:

- “Хотын стандарт” гэдэг нь одоо байгаа Монгол улсын Үндэсний стандарт болон Барилгын норм ба дүрэм гэсэн баримт бичигтэй ямар холбоотой вэ?
- Энэ нь одоогоор Монгол улсад байхгүй байгаа шинэ стандарт боловсруулах тухай юу?
- Хотын стандарт нь үндэсний стандарт болон барилгын норм ба дүрэм баримт бичгүүдийн нэгэн адил заавал хэрэгжүүлэх болон сонгон хэрэглэх эрх зүйн үндэслэлтэй юу?
- Хотын стандарт боловсруулах үйл ажиллагаа нь үндэсний стандарт боловсруулахтай нэгэн адил дүрэм журмаар боловсруулагдаж батлагдах уу?

Хотын стандартын эрх зүйн байдлыг өнөөгийн байгаа хууль эрх зүйн орчны хувьд тодорхойлбол дараах байдалтай байна. Үүнд:

Монгол улсын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд “стандартчиллын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна” гээд Монгол улсын үндэсний стандарт, байгууллагын стандарт, олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, түүнд нийцүүлэн гаргасан гадаад улсын стандарт гэсэн байна”.

Тус хуулийн 10 дугаар зүйлд Байгууллагын стандарт хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан стандарт, аргачлалын дагуу энэ хуульд нийцүүлэн боловсруулсан байгууллагын стандартыг хэрэглэж болно”, “Байгууллагын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна” гэж заасан байна.

Нийслэл Улаанбаатар хот иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ болон иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг хангасан барилга, зам дэд бүтэц инженерийн шугам сүлжээг үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт

шаардлагад тулгуурлан олон улсын хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн Хотын стандарт шалгуур үзүүлэлтийг тогтоож барьж байгуулах нөхцөл боломж эрх зүйн орчин бүрдсэн байна.

СТАНДАРТ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

Монгол улсад стандартын байгууллага анх 1953 онд байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Монгол улсын Засгийн газар 2016 оны 344 дүгээр тогтоолоор “Үндэсний чанарын хөтөлбөр” гэх баримт бичгийг баталсан байна. Энэхүү баримт бичиг нь үндэсний чанарын дэд бүтцийн эрх зүйн орчныг цаашид олон улсын жишигт хүргэж боловсронгуй болгох замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болгож боловсруулсан байна.

2018 оны байдлаар Монгол улсын стандартын улсын бүртгэлд 6390 стандарт, барилга хот байгуулалтын салбарт мөрдөж байгаа 298 барилгын норм ба дүрмийн баримт бичиг байна. Өнөөгийн байдлаар норм стандартын эрх зүйн орчин нь Монгол улсын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Барилгын тухай хууль болон Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо /БНБД 00-01-99/ -оор зохицуулагдаж байна.

Дээрх баримт бичгүүдэд “барилгын стандартчилал ба нормын эрх зүйн үндэс нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцаа тэдгээрийн үйлдвэрлэл үйлчилгээний болон бүтээгдэхүүний чанарын төлөө хүлээх хариуцлага, эдлэх эрх, үүргийг тодорхойлсон Монгол улсын хууль тогтоомж болно” гэсэн ба “чиглэлийн яам, улсын хяналтын байгууллагуудын норматив баримт бичигт Монгол улсын барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх мэдэлд хамаарах журам, заалтуудыг тусгахгүй байвал зохино” гэж заасан байна.

Үүнээс үзэхэд Монгол улсад “Монгол улсын үндэсний стандарт” болон барилгын салбарын чанар стандарт шаардлагыг тодорхойлсон “Барилгын норм ба дүрэм” гэсэн хоёр стандарт баримт бичгийн тогтолцоо хэрэгжиж байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтоосон стандарт, шаардлагыг хангаж байх нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн хувьд нөөцийг зүй зохистой ашиглах өндөр ач холбогдолтой бөгөөд чанарын тухай ойлголт нь түүхийн цаг үеүдэд харилцан адилгүй байсаар ирсэн.

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанарын тухай хамгийн түгээмэл ойлголт нь “Британийн стандартын байгууллага” (British Standards Institution) -ын 1987 онд анхлан боловсруулсан ISO 9000 бүлгийн стандартаар баталгаажсан байх явдал юм. Чанарын тухай ойлголтыг ISO 9000:2015 стандартад “Нэгж, хэсгийн бодит байдал нь тогтсон хэрэгцээ, хүлээлт буюу шаардлагуудыг хангаж буй түвшин” гэж тодорхойлсон байдаг.

Стандарт гэдэг нь “Тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ”, “Бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг иш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг техникийн зохицуулалт гэнэ” гэж Монгол улсын Стандартчилал техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд томъёолсон байна.

СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

“Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар” нь Нийслэлийн хэмжээнд стандартын хэрэгжилтийг хотын гудамж зам талбайн орчин, дэд бүтцийн хангамж мөн Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа стандарт баримт бичгийн судалгааг ажлыг 2019 оны зургаа, долоо дугаар саруудад хийж гүйцэтгэсэн байна. Уг судалгааны дүгээс үзэхэд Нийслэлийн нутгийн захиргааны болон харъя нийт 61 байгууллагаас 702 ширхэг стандарт, 619 ширхэг норм ба дүрэм, 57 ширхэг журмыг тус тус үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна гэсэн боловч гадаад орчинд хийсэн судалгаагаар орчны аюулгүй байдал алдагдсан 5’423 тохиолдол илэрсэн байна. Нийт зөрчил дутагдлын дийлэнх олонх нь явган замын засвар ашиглалт, авто замын эвдрэл, орц гарц, инженерийн шугам сүлжээний ашиглалт болон барилгын үйлдвэрлэлийн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд эзэлсэн байна.

Судалгаанаас үзэхэд хууль, дүрэм журам, норм стандартын хэрэгжилт хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна. Хууль, дүрэм, норм стандартын хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нь дараах үндэслэлтэй гэж үзсэн байна. Үүнд:

- Төрийн болон мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн чанар стандартын талаар мэдлэг ойлголт сул, шаардлага тавих чадвар, ухамсар доогуур байгаагаас илт стандартын шаардлага хангаагүй ажил үйлчилгээг хүлээн зөвшөөрч арга хэмжээ авалгүй өөгшүүлдэг.
- Төрийн болон мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлага, мэдлэг чадвар, мэргэжил, мэргэшил хангалтгүй.
- Төрийн болон мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг хянах хариуцлага хяналтын тогтолцоо байхгүй.
- Стандарт, техникийн зохицуулалтын баримт бичигт тавигдсан шаардлага нь хэт ерөнхий байдалтай, нарийн заавар зөвлөгөө дутмаг, хуучирч шинэ цагийн хот төлөвлөлт, барилгажилтын шаардлага хангахгүй болсон, мөн онол арга зүйн талаар бичсэн хэт их бичиглэлтэй, зураг схем дутмаг байдаг.

- Монгол улсын стандартын улсын бүртгэлд 6390 стандарт байгаа ба эдгээр стандартуудыг иргэд, байгууллагууд заавал биелүүлэх бус сонгож хэрэглэх нөхцөлтэй. Төрийн байгууллагуудын чиг үүрэгт стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллахаар заасан байдаг боловч, уг ажлыг мэргэжлийн хяналтын байгууллагын ажил гэж боддог байна.

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО /ISO9001:2015/

Олон улсын стандартчиллын байгууллага нь 1947 онд байгуулагдсан, дэлхий даяар 164 гишүүн орныг эгнээндээ нэгтгэсэн, хараат бус, олон улсын байгууллага юм. Тус байгууллага нь өнгөрсөн түүхийн хугацаанд 22804 стандартыг боловсруулж хэвлүүлсэн байна.

Даяарчлал, дэлхийн зах зээлийн хүчтэй өрсөлдөөний нөлөөгөөр үйлчлүүлэгч, худалдан авагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ нь чанар сэтгэл ханамжийг шаардаж байна. Өрсөлдөх чадвараа хадгалахын тулд байгууллагууд Олон улсын стандартчиллын байгууллагаас боловсруулсан Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001, Хүнсний аюулгүй байдлын менежмент ISO22000, Байгаль орчны менежмент ISO14000 болон Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт ISO45000, Хотын тогтвортой хөгжлийн стандарт ISO 37000 зэрэг стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай болж байна.

Хотын стандарт боловсруулж хот байгуулалтын дэд бүтцийг бүтээн байгуулах, мөн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарын шаардлагыг тогтоох үйл ажиллагаа нь дангаараа үр дүнд хүрэх боломж хязгаарлагдмал бөгөөд стандартыг хэрэгжүүлэх нэвтрүүлэх талаар хийгдсэн судалгааны дүнгээс үзэхэд стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь байгууллага, хувь хүний дотоод хүсэл зориг ухамсраас урган гарах нь стандарт хэрэгжих нөхцөл бололцоог илүү бүрдүүлж ажил үйлчилгээний чанар сайжрах үндэс болж байна гэж тогтоосон байна.

